



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 2.4, 3.2, 2 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ын 12, 43 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас шагнал олгоход мөрдөх журам”-ыг нэгдүгээр, “Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас олгох шагналд нэр дэвшигчийн анкет”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх журмыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Жавхлан/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/88 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мэдээлэл, харилцаа холбооны салбарын шагналын журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД БӨГӨӨД ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН
ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ



Л.ЭНХ-АМГАЛАН

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2022 оны 07 сарын 09 -ны өдрийн АЗ дугаартай
тушаалын нэгдүгээр хавсралт

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНААС ШАГНАЛ ОЛГОХОД МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэхэд онцгой амжилт, идэвх зүтгэл гаргаж, үр бүтээлтэй ажилласан салбарын байгууллагад ажиллаж байгаа ажилтан, албан хаагч, Монгол Улсын болон гадаад улсын иргэн /цаашид “нэр дэвшигч” гэх/-ийг “Засгийн газрын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг болон Цахим, хөгжил харилцаа холбооны яамны шагналд нэр дэвшүүлэх, шагнах, шагнахаас татгалзах, салбарын шагналыг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын инженер, техникийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд идэвх зүтгэл гаргаж бодитой хувь нэмэр оруулсан бусад байгууллагын ажилтан, албан хаагч, гадаадын иргэнийг дээрх шагналаар шагнаж болно.

Хоёр. Шагналын төрөл

- 2.1 Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас “Засгийн газрын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, “Цахим, хөгжил харилцаа холбооны яам”-ны шагнал (цаашид “салбарын шагнал” гэх)-ыг олгоно.
- 2.2 Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас олгох шагнал нь дор дурдсан төрөлтэй байна:
- 2.2.1 Засгийн газрын тэргүүний ажилтан:
- 2.2.1.1. “Мэдээлэл, харилцаа холбооны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;
- 2.2.1.2. “Шуудангийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;
- 2.2.2 Цахим хөгжил, харилцаа холбооны яамны шагнал:
- 2.2.2.1. “Хүндэт дэвтэр”-т бичиж дурсгалын гэрчилгээ олгох;
- 2.2.2.2. “Хүндэт холбоочин” тэмдэг;
- 2.2.2.3. “Жуух бичиг”.
- 2.3 Салбарын шагналыг дараах нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан олгоно:
- 2.3.1 Цагаан сар /2 дугаар сар/;
- 2.3.2 Дэлхийн мэдээлэлжсэн нийгмийн өдөр /5 дугаар сар/;
- 2.3.3 Мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажилтны өдөр, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр /7 дугаар сар/;
- 2.3.4 Ахмадын өдөр, /10 дугаар сар/;
- 2.3.5 Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр, Шинэ жил /12 дугаар сар/.
- 2.4 Салбарын шагналыг байгууллагын ой болон насны ойг тохиолдуулан олгохгүй.

2.5 Гадаадын иргэнд олгох салбарын шагналын үнэмлэхийг англи хэл дээр хэвлэсэн байна.

Гурав. Шагнал олгох болзол

3.1 Салбарын шагналыг шат дараалан, давхардуулахгүйгээр олгох бөгөөд ажлын амжилт, бүтээл нь өмнөх үзүүлэлтээс ахисан нөхцөлд дараагийн шагналд нэр дэвшүүлнэ. Онцгой гавьяа байгуулсан тохиолдолд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын шийдвэрээр салбарын шагналыг болзол харгалзахгүй олгож болно.

3.2 Салбарын шагналд энэхүү журмын 3.4, 3.5, 3.6, 3.7-д заасан болзол хангасан ажилтныг нэр дэвшүүлэх ба шагналд тодорхойлох ажилтны хяналтын тоог өөрийн байгууллагын нийт ажиллагсдын 10-15 хувиас хэтрүүлэхгүй байна.

3.3 “Мэдээлэл, харилцаа холбооны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийг бусад салбарын “Тэргүүний ажилтан” хүндэт тэмдэгтэй давхардуулан олгохгүй байх зарчмыг баримтална.

3.4 Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан, мэдээлэл, харилцаа холбооны салбарт, эсхүл мэдээлэл, харилцаа холбооны чиглэлийн мэргэжлээр 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж амжилтад хүрсэн, амжилт бүтээл нь хамт олон, мэргэжлийн хүмүүст үнэлэгдсэн, мэргэжлийн туршлага, өндөр ур чадвартай ажилтан, албан хаагчдыг “Мэдээлэл, харилцаа холбооны тэргүүний ажилтан”, “Шуудангийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнана.

3.5 Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан, мэдээлэл, харилцаа холбооны салбарт, эсхүл мэдээлэл, харилцаа холбооны чиглэлийн мэргэжлээр 10-оос доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж амжилтад хүрсэн, амжилт бүтээл нь хамт олон, мэргэжлийн хүмүүст үнэлэгдсэн, мэргэжлийн туршлага, өндөр ур чадвартай ажилтан, албан хаагчдыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны “Жуух бичиг”-ээр шагнана.

3.6 Цахим хөгжил, харилцаа холбооны яамны “Хүндэт дэвтэр”-т харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж, тус салбараас тодорхойлон “Монгол Улсын баатар”, “Монгол Улсын Хөдөлмөрийн баатар”, “Монгол Улсын Гавьяат холбоочин” хүндэт цол хүртсэн ажилтан, албан хаагчдын нэрийг бичиж, дурсгалын гэрчилгээ олгоно.

3.7 Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан, мэдээлэл, харилцаа холбооны салбарт мэргэжлээрээ тасралтгүй 25-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж амжилтад хүрсэн, амжилт бүтээл нь хамт олон, мэргэжлийн хүмүүст үнэлэгдсэн, мэргэжлийн туршлага, өндөр ур чадвартай ажилтан, албан хаагчид “Хүндэт холбоочин” тэмдэг олгоно.

3.8 Салбарын шагналаар шагнахад нэр дэвшигчийн дор дурдсан шалгуурыг харгалзан үзнэ:

3.8.1 салбарын ажил үйлчилгээг хөгжүүлэхэд нээлт, шинэ бүтээл гаргасан, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд ач холбогдолтой техник, технологи нэвтрүүлсэн;

3.8.2 Монгол Улсын болон олон улсын тэмцээн, уралдаанд амжилттай оролцож байр эзэлсэн байдал;

- 3.8.3 төрийн албан хаагчийн хувьд мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж буй байдал;
- 3.8.4 тухайн салбарт тогтвор суурьшилтай ажилласан байдал;
- 3.8.5 үндсэн сүлжээ, техник тоног төхөөрөмж, үйлдвэрлэл үйлчилгээнд учирч болох ноцтой аваар ослоос урьдчилан сэргийлж, таслан зогсоох арга хэмжээ авсан, ослын хохирлын хор, уршгийг арилгах ажилд онцгой үүрэг гүйцэтгэсэн байдал.
- 3.9 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт онцгой амжилт гаргасан тохиолдолд салбарын шагналыг хугацаа харгалзахгүй олгож болно.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

- 4.1 Салбарын шагналд нэр дэвшүүлэх санаачилгыг өмчийн аливаа хэлбэрийг харгалзахгүйгээр төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагаас гаргаж болно.
- 4.2 Салбарын шагналд нэр дэвшүүлэх хүсэлтийг байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй дарга, гүйцэтгэх захирал гаргана.
- 4.3 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын байгууллагад ажиллаж байгаа ажилтан, албан хаагч, өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настныг үндсэн байгууллага нь шагналд тодорхойлно.
- 4.4 Аль нэг байгууллага, аж ахуйн нэгжид харьяалагддаггүй ахмад настныг оршин сууж байгаа сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас шагналд тодорхойлно.
- 4.5 Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, бусад олон нийтийн байгууллагаас харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын байгууллагад ажиллаж байгаа ажилтан, албан хаагчийг салбарын шагналаар шагнуулах хүсэлтийг гаргахад нэр дэвшигчийн ажиллаж байгаа байгууллагаас албан бичгээр санал авсан байна.
- 4.6 Салбарын шагналаар шагнуулах тухай хүсэлт, дагалдах материалыг энэ журмын 2.3-д заасан нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр болохоос 1 (нэг) сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр ирүүлсэн байвал зохино.
- 4.7 “Жуух бичиг”-ээр шагнуулснаас хойш 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж, ажлын амжилт бүтээл нь өмнөх үзүүлэлтээс ахисан тохиолдолд дахин салбарын шагналд нэр дэвшүүлнэ.
- 4.8 Нэр дэвшигчийн материалыг хугацаа хожимдуулсан, нэр дэвшигчийн тодорхойлолтыг дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн, шагналд нэр дэвшүүлэх болзлыг хангаагүй ажилтан, албан хаагчийг тодорхойлж ирүүлсэн тохиолдолд үндэслэлийг дурдан тодорхойлсон байгууллагад нэр дэвшигчийн материалыг буцаана.
- 4.9 Нэр дэвшигчийн талаар дор дурдсан материалыг бүрдүүлж, хүсэлтэд хавсаргана:
- 4.9.1 Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас олгох шагналд нэр дэвшигчийн анкет /3*4 хэмжээтэй цээж зураг наасан байх/;
- 4.9.2 ажил байдлын тодорхойлолт /нэр дэвшигчийг шууд харьяалах удирдах албан тушаалтнаас тодорхойлсон байх/;
- 4.9.3 ажлын үр дүнгийн үзүүлэлт /бүтээлийн жагсаалт/;
- 4.9.4 урьд шагнагдсан бол шагналын үнэмлэхийн хуулбар;
- 4.9.5 онцгой амжилт гаргасан бол энэ тухай танилцуулга;

- 4.9.6 ажилласан жилийг нотлох түүнтэй адилтгах баримт бичиг /нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт (цалин хөлс, шимтгэл төлөлтийн хэсгийг дарсан байх);
- 4.9.7 шагналд тодорхойлох ажилтны хяналтын тоог баримталсныг нотлох баримт болох Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт;
- 4.9.8 төрийн шагналд уламжилж байгаа бол хамт олны хурлын тэмдэглэл.
- 4.10 Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолтод ажлын амжилт, авьяас чадвар, байгууллагад оруулсан хувь нэмрийг тодорхой бичсэн байна.

Тав. Шагнал олгох

- 5.1 Төрийн захиргааны удирдлагын газрын шагнал урамшууллын асуудал хариуцсан албан хаагч нэр дэвшигчийн бичиг баримтын бүрдэл, үнэн зөв байдал, байгууллагын хяналтын тоонд багтсан эсэхийг нягтлан үзэж энэхүү журамд заасан болзол, шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, холбогдох саналаа удирдлагад танилцуулна.
- 5.2 Энэхүү журамд заасан болзол, шаардлагыг хангасан нэр дэвшигчийг салбарын шагналаар шагнуулахаар нэрсийг Төрийн нарийн бичгийн дарга, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдад танилцуулж, зөвшөөрөл авах ба шагнах асуудлыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд тушаал гаргаж шийдвэрлэнэ.
- 5.3 Тус яамны “Хүндэт дэвтэр”-т бичих шийдвэрийн төслийг Төрийн захиргааны удирдлагын газрын шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулах ба Төрийн нарийн бичгийн дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ.
- 5.4 “Засгийн газрын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, “Хүндэт холбоочин” тэмдэг, “Жуух бичиг”-т хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн тухай гэрчилгээ олгоно.
- 5.5 Шагнагдсан иргэний хүндэт тэмдэг, үнэмлэх, “Жуух бичиг”-ийг шагнах тухай шийдвэрийн хамт тодорхойлсон байгууллагын хүний нөөцийн ажилтанд хүлээлгэн өгнө.

Зургаа. Монгол Улсын төрийн дээд цол, одон медаль, хүндэт өргөмжлөлөөр шагнуулахаар тодорхойлох, уламжлах, өргөн мэдүүлэх

- 6.1 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын байгууллагад ажиллагсдыг Монгол Улсын төрийн дээд цол, одон медаль, хүндэт өргөмжлөлөөр шагнуулах талаар холбогдох байгууллагын удирдлага санал дэвшүүлэх ба шагналд нэр дэвшигчийн ажлын үр дүн, шинэ бүтээл, санаачилсан тэргүүн туршлага зэргийг тусгасан тооцоо судалгаатай, тоон үзүүлэлттэй тодорхойлолтыг төрийн шагналын анкет, хамт олны хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэлийн хамт бүрдүүлэн ирүүлнэ.
- 6.2 Тэмдэглэлт үйл явдал, ойг тохиолдуулан төрийн дээд цол, одон медаль, хүндэт өргөмжлөлөөр шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүмүүсийн материалыг тус яамны Төрийн захиргааны удирдлагын газраас судлан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-д заасны дагуу нэр дэвшүүлэн, уламжилж, цахим санд бүртгэн, өргөн мэдүүлнэ.

Долоо. Шагналын мэдээллийн сан

7.1 Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь салбарын шагналын мэдээллийн сантай байна. Мэдээллийн санд шагнагдсан иргэний овог, нэр, регистрийн дугаар, ажилласан жил, салбарын шагналаар шагнуулсан байдал, нэр дэвшигчийг тодорхойлсон байгууллагын мэдээллийг тусгасан байна.

7.2 Салбарын шагналыг төрлөөр болон оноор төрөлжүүлэн мэдээллийн санг бүрдүүлнэ.

7.3 Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөнийг Төрийн захиргааны удирдлагын газар хариуцан ажиллана.

7.4 Салбарын шагналд тодорхойлох тухай хүсэлт, холбогдох материалыг цахим системээр дамжуулан хүлээн авч болно.

Найм. Бусад

8.1 Салбарын шагналын тэмдэг, үнэмлэхийн загварыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд батална.

8.2 Салбарын шагналаар шагнуулсан инженер, техникийн ажилтан, албан хаагчид шагналд тодорхойлсон байгууллагаас мөнгөн урамшуулал олгож болно.

8.3 Салбарын шагналаар шагнуулсан Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан хаагчид шагналын сан, төсвийн хэмнэлтээс мөнгөн урамшуулал олгоно.

8.4 Энэ журам батлагдсанаас хойш олгосон “Засгийн газрын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, “Цахим хөгжил, харилцаа холбооны яам”-ны “Жуух бичиг”, “Хүндэт холбоочин” тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсэн тохиолдолд дараах баримтыг үндэслэн нөхөн олгоно:

8.4.1 үрэгдүүлсэн, гэмтээсэн нөхцөл шалтгааныг тодорхой бичсэн хүсэлт бүхий өргөдөл;

8.4.2 шагнагдсан иргэний үнэмлэхийн хуулбар;

8.4.3 шагналд нэр дэвшүүлж байсан байгууллагын тодорхойлолт;

8.4.4 үрэгдүүлсэн тухай зарлуулсан баримт;

8.4.5 хүндэт тэмдэг, үнэмлэхийн бэлдцийн зардлыг тушаасан баримт.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2022 оны 07 сарын 04 -ны өдрийн АХ дугаартай
тушаалын хоёрдугаар хавсралт

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМНААС ОЛГОХ ШАГНАЛД
НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ**

1. Овог:
2. Нэр:
3. Хүйс:
4. Төрсөн аймаг, сум, хот:
5. Одоогийн харьяалал:
6. Регистрийн дугаар:
7. Боловсрол:
8. Эзэмшсэн мэргэжил:
9. Ажилладаг салбар:
10. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

3x4

Д/д	Ажлын газрын нэр	Ажилласан хугацаа	Эрхэлсэн ажил, албан тушаал

11. Урьд нь шагнагдаж байсан шагналууд: /Монгол Улсын цол, одон, медаль, Засгийн газрын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны шагналаар шагнуулсан байдлыг бичих/

Д/д	Шагналын нэр	Хэдэн онд

12. Шагнуулах үндэслэл:
13. Нэр дэвшүүлсэн шагналын нэр:
14. Хамт олны саналын хувь:

Анкетыг баталгаажуулсан:

Хүний нөөцийн ажилтан

(гарын үсэг)

.....
(гарын үсгийн тайлал)

.... оны сарын -ны өдөр